



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

14193 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их тойруу 81/1, Утас/Факс: (976-11) 35 00 60,
И-мэйл: info@customs.gov.mn, Вэбсайт: www.customs.gov.mn

2023.07.28 № 01/2685

танай _____ -ны № _____ -Т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

Төсвийн төслийн санал хүргүүлэх
тухай.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон Засгийн газраас авч хэрэгжүүлж буй Шинэ сэргэлтийн бодлого-боомтын шинэчлэлийн хүрээнд, хүрэх үр дүнг баримтлан гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, гаалийн харилцаанд оролцогчид үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэн олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, хилийн боомтын болон гүний гаалийн байгууллагын дэд бүтэц, үйл ажиллагааг сайжруулах, мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, гаалийн мэдээллийн санг боловсронгуй болгох, улсын төсвийн орлогыг бүрдүүлэн ажиллахаар зорилт тавьж Монгол улсын Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу 2024 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсвийн төслийн саналыг боловсрууллаа.


Тус төсөлд гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах: журмын хэрэгжилтийг хангах, албан хаагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулах, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж буй боомтуудын бүтээн байгуулалтын ажлуудын зарим хэсэг нь 2024 онд ашиглалтад орох, байр ашиглалттай холбоотой тогтмол болон урсгал зардал, гаалийн байгууллагын ажиллах орон тоо, цалин хөлс, гаалийн үйлчилгээг цахимжуулах, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, зохион байгуулах уулзалт, сургалтын арга хэмжээний зардлыг тооцож тусган хавсралтаар хүргүүлж байна.

Манай байгууллагын ирэх оны төсвийн төслийг судлан үзэж, шийдвэрлэж өгнө үү.

Хавсралт хуудастай.
ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

1439607 2808



Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн төслийн саналд тусгасан төсөл, арга хэмжээний танилцуулга

Гаалийн байгууллагын 2024 оны Тус төсвийн төслийн саналд дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, урсгал төсвийг тооцон тусгалаа. Үүнд:

1. Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газарт “Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга” шинээр барих;
2. Увс аймаг дахь Гаалийн газрын “Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга” угсралтын ажлын дэд бүтцийн техникийн нөхцөлтэй холбоотой нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлэн, ажлыг дуусгах;
3. Монгол Улсын Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлого-боомтын шинэчлэлийн хүрээнд хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж байгаатай уялдуулан хилийн боомтууд болон гүний гаальд ажиллаж буй албан хаагчдын зарим орон сууцыг шинэчлэхэд шаардлагатай орон сууцны барилгын нэг маягийн зураг төсөл боловсруулах;
4. 2024-2025 ондууд шинээр баригдах барилга байгууламжуудын зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зардал тухайлбал гадаад худалдааны бараа эргэлт жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотой гаалийн мэдүүлгийн тоо сүүлийн жилүүдэд багадаа 50 хүртэл хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Гаалийн мэдүүлэг болон дагалдах бичиг баримтыг архивын тухай хуулиар 5 болон түүнээс дээш жил хадгалах шаардлагатай байдаг тул архивын зориулалттай өрөө тасалгааны хүрэлцээгүйгээс шалтгаалан Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газруудын архивын нэгдсэн барилгатай байх хэрэгцээ шаардлага үүссэн;
5. Зарим хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагатай барилга байгууламжуудын их засварын зардал;
6. Гаалийн газар, хороодын албан хаагчдыг хилийн боомт руу зөөвөрлөх, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой ашиглаж буй нийт автомашин, техник хэрэгслүүдийн 88.8 хувь нь ашиглалтын хугацаа дуусч, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байдалд хүрсэн, сүүлийн жилүүдэд парк шинэчлэлт хийгдээгүй, замын хөдөлгөөнт оролцох боломжгүй байдалтай байгаа тул зайлшгүй шаардлагатай 29 тээврийн хэрэгслийг шинэчлэх;
7. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо, Бичигт боомтуудын бүтээн байгуулалтын ажлууд ашиглалтад орж байгаатай холбогдуулан шаардлагатай гаалийн хяналт шалгалтын болон лабораторийн тоног төхөөрөмжүүдийг худалдан авах;
8. Гаалийн байгууллагын Дата төвийн мэдээллийн аюулгүй байдлын хөргөлтийн болон хамгаалалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх;
9. “Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын лабораторийн тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/-д төсөл, арга хэмжээний хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Тоног төхөөрөмж нийлүүлэх, угсрах, шалгах, хүлээлгэн өгөх ажил гүйцэтгэх гэрээ”-г ХБНГУ-ын “Bachmann GmbH” ХХК-тай байгуулсны дагуу Эрдэнэт үйлдвэрт, Оюутолгой, Шивээхүрэн боомтод суурилуулалтын ажил хийгдэж

байгаа хэдий ч гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа тул тус төслийг энэ онд дуусгавар болгохоор тооцсон;

10. "Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт, шалгалтын тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр ОХУ-ын "ISB.A" ХХК-тай "Хяналтын систем нийлүүлэх, угсрах болон шалгах ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулсны дагуу Шивээхүрэн, Замын-Үүд, Боршоо боомтуудад суурилуулалтын ажил хийгдэж байгаа ба БНХАУ-ын Засгийн газрын 600,0 сая юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Монгол улсын боомтын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж" төслийн явц эрчимжиж, БНХАУ-ын тоног төхөөрөмжийн бүтээгдэхүүний импорт экспортын нийгэмлэгээс төслийн баг хилийн боомтуудад ажиллаж, шаардлагатай гаалийн хяналт шалгалтын төхөөрөмжийн судалгаа гарган, ТЭЗҮ боловсруулах ажил хийгдэхээр төлөвлөж байгаа тул ОХУ-ын "ISB.A" ХХК-тай байгуулсан дээрх гэрээг энэ онд дуусгавар болгохоор тооцсон.

11. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй боомтуудын бүтээн байгуулалт ИРЭХ ОНД бүрэн ашиглалтад орохтой холбогдуулан гаалийн хяналтын шалгалтын төхөөрөмжүүд, рентген төхөөрөмжүүдийг ажиллуулах инженер, техникийн албан хаагч, салбар лабораториуд, Эрэлч нохойн албыг бэхжүүлэх зэрэгт нийт 100 орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг тооцож тусгасан;

12. Уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлээр Дорноговь аймгийн Ханги боомтыг хариуцаж буй Сайншанд дахь Гаалийн газрын Ханги салбарыг бие даасан газар болгон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчлөх мөн Замын-Үүд Эрээний боомтыг 24 цагаар ажиллуулахтай холбоотой нийт орон тоог 142-оор нэмэгдүүлж, холбогдох урсгал зардлыг тооцсон;

13. Боомтуудын бүтээн байгуулалтын ажлууд зарим хэсэг нь 2023 онд дуусч ашиглалтад орсон хэдий ч урсгал болон байр ашиглалтын зардал хүрэлцэхгүй өр үүсэх нөхцөл байдалтай байгаа, ирэх оноос зарим хэсэг нь ашиглалтад орохтой холбоотой барилга, байгууламжуудын урсгал болон байр ашиглалтын зардлыг төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдээс холбогдох тооцоо судалгааг гаргуулсан;

14. Гаалийн байгууллагад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн албаны зөвлөл, Авилгатай тэмцэх газар зэрэг байгууллагуудаас хийсэн хүний нөөцийн бүрдүүлэлт, хангалтын талаарх шалгалтын дүн, хүний нөөцийн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний тухай нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнг үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/367 дугаар тушаалаар баталсан "Гаалийн улсын байцаагчийг шилжүүлэн ажиллуулах журам"-ын хэрэгжилтийг хангуулахаар холбогдох зардлыг тооцсон;

15. Гаалийн байгууллагын албан хаагчдыг хилийн боомтоос гаалийн хяналтын бүс рүү зөөвөрлөх, алслагдмал хилийн боомтуудаас ар гэртээ хүрэх зэрэгт замын унаа, тээврийн хэрэгслээр зорчиж, аюулгүй байдлыг нь бүрэн хангаж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж, албан хаагчдыг ирэх онд гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулах зардлыг тусгасан;

16. Сүүлийн жилүүдэд боомтын шинэчлэлийн хүрээнд гаалийн хяналт шалгалтын болон лабораторийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх ажил эрчимтэй хийгдэж, орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа хэдий ч байгалийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр гэмтэх, шатах, эвдрэх нөхцөл байнга үүсч байгаа тул эдгээр тоног төхөөрөмжүүдийг эд хөрөнгийн даатгалд хамруулахаар тооцсон;

17. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, программ хангамжийн албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөрийг 2023 онд АХБ-наас санхүүжүүлэн шийдвэрлэж байгаа бөгөөд хугацаа нь 2024 оны 3 дугаар сард дуусах тул үргэлжлүүлэн сунгах төлбөрийг тооцоолсон;

18. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж Гаалийн төв лабораторийг БНХАУ-ын CNAS бүс нутгийн итгэмжлэлд хамрагдсан бөгөөд шинээр байгуулагдсан 6 салбар лабораториудыг үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамруулах талаар Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу зөвлөх үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байгаа ба уг үйлчилгээтэй холбоотой ирэх онд гарах зардлыг тооцсон;

19. Ирэх онд боомтуудын бүтээн байгуулалт дуусч, бүрэн ашиглалтад орохтой холбогдуулан Гаалийн төв болон 12 салбар лабораториудын өдөр тутмын үйл ажиллагаа, шинжилгээ хийхэд шаардлагатай стандарт дээж, бодис урвалж, шил сав эдлэлийг худалдан авах зардлыг тооцсон;

20. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг тус тус үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын А/290 дугаар тушаалаар баталсан "Гаалийн байгууллагын ахмадын сангийн журам"-ын хэрэгжилтийг хангуулахаар холбогдох зардлыг тооцсон;

21. Гаалийн тухай хуулийг шинэчлэн батлуулахтай холбоотой хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, шинжлэх, зөвлөх багын үйлчилгээ авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, судалгаа хийх зэрэг зардлыг тооцсон;

22. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлж, зохион байгуулах уулзалт, сургалтын арга хэмжээг тооцон тус тус тусгалаа.

23. Мөн байгууллагын туслах үйл ажиллагааны орлогыг хилийн боомтуудад гаалийн хяналт бүрдүүлэлтэд ашиглагддаг нэг удаагийн троссон ломбоны үнэ, мэдүүлгийн үнэ бүрдүүлдэг ба улсын төсвийн орлогын өөрийн орлогын бүрэлдэхүүнд багтаж, төвлөрүүлж байгаа хилийн боомтуудын ариутгалын хураамжийн орлогыг байгууллагын туслах үйл ажиллагааны орлогод оруулан тооцож, урсгал зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн.

Нийт 139,8 тэрбум төгрөгийн урсгал төсөв, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд 55,2 тэрбум төгрөгийн саналыг бэлтгэж, төсвийн төлөвлөлтийн Fiscal программ, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж байна.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

МАЯГТ ТМ-01. ТӨСВИЙН САНАЛ

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨВ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

| Код | Эдийн засгийн ангилал | 70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт | | | | | | | | | | |
|---|---|---|---------------------|----------|----------------------|----------------------|----------------------|-----------|----------|----------|----------|----------|
| | | ГҮЙЦЭГТЭЛ | | | САНАЛ | | ТӨСӨӨЛӨЛ | | ӨӨРЧЛӨЛТ | | | |
| | | 2022 Гүйц | 2023 ХБГ | 2024 Хяз | 2024 ТЭЗ санал | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2022 Гүйц | 2023 ХБГ | 2024 хяз | 2024 бат | 2024 хяз |
| 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | | | | |
| А. ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЗҮЙЛС | | | | | | | | | | | | |
| 2101 | Цалин хөлс болон урамшил | 35,051,132.2 | 32,432,268.5 | | 83,059,457.2 | 107,977,294.4 | 140,370,482.7 | 108.1 | % | | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх | 4,507,450.2 | 3,788,230.4 | | 11,173,138.6 | 14,525,080.2 | 18,882,604.3 | 119.0 | % | | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,926,332.0 | 2,523,463.9 | | 8,448,046.7 | 10,982,460.7 | 14,277,198.9 | 76.3 | % | | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,155,679.7 | 655,928.9 | | 2,561,294.1 | 3,329,682.4 | 4,328,587.1 | 176.2 | % | | | |
| 2105 | Норматив зардал | 4,756,672.4 | 2,297,365.4 | | 6,350,205.4 | 8,255,267.0 | 10,731,847.1 | 207.0 | % | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал зардал | 3,176,789.2 | 2,827,253.8 | | 11,039,415.4 | 14,351,240.0 | 18,656,612.0 | 112.4 | % | | | |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 234,496.6 | 201,668.2 | | 920,355.4 | 1,196,462.0 | 1,555,400.6 | 116.3 | % | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн АУТХ | 3,215,629.6 | 5,239,674.1 | | 9,797,561.6 | 12,736,830.1 | 16,557,879.2 | 61.4 | % | | | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 750,366.1 | 158,466.4 | | 1,161,564.2 | 1,510,033.5 | 1,963,043.5 | 473.5 | % | | | |
| 2113 | Урсгал шилжүүлэг | 1,773,166.8 | 1,079,733.7 | | 5,266,901.3 | 6,846,971.7 | 8,901,063.2 | 164.2 | % | | | |
| 22 | Хөрөнгийн зардал | | | | | | | % | | | | |
| НИЙТ | | 56,547,714.7 | 51,204,053.3 | - | 139,777,940.0 | 181,711,322.0 | 236,224,718.7 | | | | | |
| Б. ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ-АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | | | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 52,018,839.2 | 45,561,473.0 | | 128,403,891.0 | 166,925,058.3 | 217,002,575.8 | 114.2 | % | | | |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ | 1,324,756.0 | 3,715,885.1 | | 3,907,902.3 | 5,080,273.0 | 6,604,354.9 | 35.7 | % | | | |
| 80205 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | | 22,849.6 | | 121,668.4 | 158,168.9 | 205,619.6 | | % | | | |
| 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 376,470.2 | 327,830.9 | | 689,328.0 | 896,126.4 | 1,164,964.3 | 114.8 | % | | | |
| 80220 | Холбооны суваг ашигласны төлбөр | 956,023.3 | 465,066.5 | | 1,138,249.0 | 1,479,723.6 | 1,923,640.7 | 205.6 | % | | | |
| 80305 | Биеийн тамир, уралдаан тэмцээн | | | | 20,000.0 | 26,000.0 | 33,800.0 | | % | | | |
| 80313 | Дээж худалдан авалт | 83,065.7 | 20,000.0 | | 100,000.0 | 130,000.0 | 169,000.0 | 415.3 | % | | | |
| 80811 | Нүүлэн шилжүүлэх зардал | 15,393.6 | 9,814.5 | | 130,000.0 | 169,000.0 | 219,700.0 | 156.8 | % | | | |
| 80509 | ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж | 79,824.6 | 90,000.0 | | 96,200.0 | 125,060.0 | 162,578.0 | 88.7 | % | | | |
| 80802 | Ажил олгогчоос олгох, тэтгэмж, урамшуулал | 1,693,342.1 | 991,133.7 | | 5,170,701.3 | 6,721,911.7 | 8,738,485.2 | 170.8 | % | | | |
| НИЙТ | | 56,547,714.8 | 51,204,053.3 | - | 139,777,940.0 | 181,711,322.0 | 236,224,718.6 | | | | | |
| В. САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | | | | | | | | | | | |
| 310003 | 31-ын тусгай сан | 67,730,955.0 | 83,775,331.8 | | 136,550,792.8 | 178,484,174.8 | 232,997,571.3 | | % | | | |
| 310002 | Тусгай зориулалтын шилжүүлэг | | | | | | | | % | | | |
| 32 | Орон нутгийн төсөв | | | | | | | | % | | | |
| 33 | Нийгмийн даатгалын сан | | | | | | | | % | | | |
| 35 | Үйл ажиллагааны орлого | 1,227,147.2 | 1,227,147.2 | | 3,227,147.2 | 3,227,147.2 | 3,227,147.2 | | % | | | |
| 36 | Тусламж | | | | | | | | % | | | |
| 37 | Бусад эх үүсвэр | | | | | | | | % | | | |
| НИЙТ | | 68,958,102.2 | 85,002,479.0 | - | 139,777,940.0 | 181,711,322.0 | 236,224,718.5 | | | | | |
| Г. ХӨТӨЛБӨРИЙН ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | | | | | | | | | | | |
| 1 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1,466.0 | 1,904.0 | | 2,146.0 | 2,146.0 | 2,146.0 | | % | | | |
| 2 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 449.0 | 422.0 | | 422.0 | 422.0 | 422.0 | | % | | | |
| 3 | Төрийн үйлчилгээний (ТҮ) | | | | | | | | % | | | |
| НИЙТ | | 1,915.0 | 2,326.0 | - | 2,568.0 | 2,568.0 | 2,568.0 | | | | | |
| Д. ХӨТӨЛБӨРТ ХАМААРАХ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАР | | | | | | | | | | | | |
| 1024111 | Уламжлалт анагаах ухааны төв | | | | | | | | % | | | |
| 1024102 | Рашаан сувиллын газар | | | | | | | | % | | | |

1024500 Түргэн тусламж

%

%

%

| | | | | |
|------|---------|---------|---------|---------|
| НИЙТ | 1,915.0 | 2,326.0 | 2,568.0 | 2,568.0 |
|------|---------|---------|---------|---------|

ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

*Санхүүжилтийн эх үүсвэр, хөтөлбөрийн зардал, зардлын зориулалт болон арга хэмжээ болон байгууллагаар хуваарилсан дүн хоорондоо тэнцэж байх ёстой.

Е. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ ЗОРИЛТУУД (ДУНД ХУГАЦААГААР)

- ЗОРИЛТ 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах,
- ЗОРИЛТ 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх,
- ЗОРИЛТ 3: Улсын төсвийн орлогыг шуударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх,
- ЗОРИЛТ 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

Ж. ТӨСВИЙН ХЯВГААРААС ДАВСАН САНАЛЫН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР, НОТЛОГОО

МУ-ын Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор Коронавируст халдвар (Ковид-19)-г цар талын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хягаарлах хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх зорилготой "Шинэ сэргэлтийн бодлого"-ийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, боомтын бүтээн байгуулалтын ажлыг түргэвчлүүлэн, тоног төхөөрөмжийн угсралтыг зэрэгцүүлж хийхээр үе шаттай зохион байгуулагдаж буй төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулан Гаалийн байгууллагын 2024 оны урсгал зардлыг тооцон төлөвлөвөө. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил НДШ: Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу нийт албан хаагчдын цалин хөлсийг тооцож төсөвлөсөн. Мөн Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын дагуу төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулалыг нэмж олгох, Монгол улсын засгийн газрын 198 дугаар тогтоолоор "Хятад, Монголын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ээр Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхонгор, хилийн боомтод ажиллаж байгаа албан хаагчдын Бямба, Ням гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдөр ажиллуулахад гарах цалин хөлсний зардлыг Засгийн газраас шийдвэрлэж байхаар тусгасан. Мөн Гашуунсухайт, Шивээхүрэн, Алтанбулаг, Замын-Үүд, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газруудын ажиллах цагийг нэмэгдүүлснээр албан хаагчдад илүү цаг олгохоор тооцож төсөвлөсөн. БНХАУ-ын Засгийн газрын бүтэцтэй тусламж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй боомтуудын бүтээн байгуулалт 2024 онд бүрэн ашиглалтад орохтой холбогдуулан гаалийн хяналтын шалгалтын төхөөрөмжүүд, рентген төхөөрөмжүүдийг ажиллуулах инженер, техникийн албан хаагч, салбар лабораториуд, Эрэлч нохойн албыг бэхжүүлэх зэрэгт нийт 100 орон тоог мөн үйл уурхайн эрдэс бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлээр Дорноговь аймгийн Ханги боомтыг харууцаж буй Сайншанд дахь Гаалийн газрын Ханги салбарыг бие даасан газар болон зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн өөрчлөх, Замын-Үүд, Эрээнний боомтыг 24 цаг цагаар ажиллуулахтай холбоотой нийт орон тоог 142-оор нэмэгдүүлж цалин хөлс нэмэгдэл урамшиллын зардлыг тооцоолсон.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал: Хөшигийн хөндий дэх Нэг цэгийн үйлчилгээний барилга, байгууламжууд болон төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй Замын-Үүд, Алтанбулаг, Бичиг, Боршоо боомтуудын бүтээн байгуулалтуудын зарим хэсэг 2023 онд ашиглалтад орсон хэдий ч урсгал болон байр ашиглалтын зардал хүрэлцэхгүй өр үүсэх нөхцөл байдалтай байгаа, ирэх оноос зарим хэсэг нь ашиглалтад орохтой холбоотой барилга, байгууламжуудын байр ашиглалтын зардлыг төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдээс холбогдох тооцоо судалгааг гаргуулан авч тусгасан.

Нормативт зардал: Эм бэлдмэл ангилалд: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбоотой ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис худалдан авах зардал мөн гаалийн болон хорио цээрийн лабораториудад шаардлагатай урвалж бодис, бусад туслах материалын зардал, гаалийн албаны эрэлч ноход жилдээ 1 удаа галзуугын вакцин мөн олон цэнэгт вакцинд хамруулах улирал тутамд гадна болон дотор паразитын эсрэг эм бэлдмэл мөн шаардлагатай бусад хэрэгжүүлэх эм бэлдмэлээр хангах, нохойн хоолны сав гадна талбай Ур ариутгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бэлдмэл худалдан авах зардлыг тус тус төсөвлөсөн. Хоол хүнс ангилалд албаны 50 гаруй эрэлч нохойн зориулалтын хоолны зардлыг төсөвлөсөн. Эрэлч нохойн өдрийн хоолны норм нь том нохойнд 1 удаадаа 750 гр ба жижиг нохойнд 500 грамаар бодогдож олгодог. Уг тогтоосон норм нь нохойн өдөр тутмын хэрэгцээг хангахад дутагдалтай байдаг учраас 2 дахин нэмэгдүүлэх, мөн үйлдвэрийн хоолнууд нь өвлийн улиралд нохойн биеийн дулааныг хадгалахад муу байдаг ба нэмэлтээр мах махан бүтээгдэхүүнүүдийг авч хэрэглэх шаардлагатай байна гэдэг саналыг эрэлч нохойн албанаас ирүүлж 1 жилд өвлийн улиралд 50кг түүхий мах, 700 ширхэг малын өвчүү, 700 ширхэг дотор гэдсгий цуглуулан авч эрэлч ноходойг хооллодог. Нэг кг нохойн зориулалтын хоолны зах зээлийн дундаж үнэ 8000 төгрөг байна. Тиймээс эрэлч нохойн хоолны норм нормативыг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн хоол хүнс ангилалд лабораторийн албан хаагчид болон ариутгалч нарын хор саармагжуулах бүтээгдэхүүний зардлыг төсөвлөсөн. Нормын хувцас зөөлөн эдлэл ангилалд нийт 2146 төрийн тусгай албан, хаагчийн дүрэмт хувцасны хангалтад 3.7 тэрбум төгрөг төсөвлөсөн.

Эд хогшил, урсгал засварын зардал: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны зориулалтаар ашиглахаар худалдан авсан багаж техник хэрэгслийн зардлууд болон албан хэрэгцээнд ашиглагдах компьютер, принтер, сканнер зэрэг тоног төхөөрөмжийг цөөн тоогоор худалдан авах зардлууд, урсгал засварын зардалд "Шинэ сэргэлтийн бодлого" хөтөлбөрийн 1 дүгээрт тусгасдан "Боомтын сэргэлт" багц асуудлын 1.1.5-д "Боомтуудын үндсэн байгууламж/эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, интеркзтийн сүлжээ, гаалийн лаборатори, зорчигч болон ачаа тээврийн терминал-ийг өргөтгөн шинэчилж, зорчигч аллах, албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлэх" гэж тусгагдасны дагуу хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хангахтай холбогдсон зардлууд багтсан.

Хөдөлмөр хамгаалал: Гаалийн төв лаборатори болон салбар лабораториудын албан хаагчид болон хорин цээрийн албаны ариутгалч, эрэлч нохойн албаны сургалч нарын хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгсэл худалдан авах зардлыг тооцож төсөвлөсөн.

Томилолт, зочны зардал: Гаалийн байгууллага нь харьяа гаалийн газар хороодод хяналт шалгалт хийх, дотоод аудит болон бусад боомтын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор харьяа 18 газар, хороонд албан томилолтоор ажилладаг тул томилолтын зардлыг Сангийн сайдын 2022 оны 12 дугаар тушаалаар батлагдсан тарифаар, шатахууны зардлыг зах зээлийн ханшаар тооцон төсөвлөсөн. Мөн гаалийн шинэчлэлийн хүрээнд харьяа боомтууд дээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлууд, төсөл хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцтай тухайн боомт дээр очиж танилцах, хяналт тавих зайлшгүй шаардлага үүсч байгаа тул тус зардлыг нэмэгдүүлж төсөвлөсөн. Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул уулзалт хурал зөвлөгөөн болон зочин төлөөлчийг хүлээн авах зайлшгүй шаардлага гардаг тул гадаад арга хэмжээтэй холбоотой зардлыг нэмж төсөвлөсөн.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж:

1. Гаалийн мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлэн худалдан авсан тоног төхөөрөмж, програм хангамж болон байгууллагын дотоод үйл ажиллагааны програм хангамжуудын албан ёсны ашиглалтын эрх бүхий лицензийн төлбөр;
2. Гаалийн лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулах олон улсын зөвлөх үйлчилгээний багтай 2020 онд гэрээ байгуулан ажиллаж Гаалийн төв лабораторийг БНХАУ-ын СНАС бүс нутгийн итгэмжлэлд хамрагдсан бөгөөд шинээр байгуулагдсан 6 салбар лабораториудыг үндэсний болон олон улсын итгэмжлэлд хамруулах талаар Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу зөвлөх үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байгаа ба уг үйлчилгээтэй холбоотой ирэх онд гарах зардлыг тооцсон;
3. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мэргэжлийн хяналтын байгууллагын үлсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүрэг Гаалийн байгууллагад шилжин ирсэнтэй холбоотой хорио цээрийн хяналт, шалгалтад ашиглагддаг 27 ширхэг маягтын хэвлүүлэх зардал, гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглагддаг "Зорчигчийн гаалийн мэдүүлгийн маягт", хатуу дугаар бүхий нэг удаагийн троссон ломбоны худалдан авалт зэргийг тооцож төсөвлөсөн.

Бараа үйлчилгээний бусад зардал: Гаалийн шинэчлэлийн хүрээнд нийлүүлэгдэж буй бараа тээврийн хэрэгслийн хяналтын рентген аппарат болон нүүрснээс дээж авагч рентген флуоресцент төхөөрөмжүүдийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар, болон Г амшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-д заасны дагуу тухайн жилийн төсвийн 1%-ийг төлөвлөж зарцуулна гэсэн заалтын дагуу зардлыг тусгасан. Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул уулзалт хурал зөвлөгөөн болон зочин төлөөлчийг хүлээн авах зайлшгүй шаардлага гардаг тул гадаад арга хэмжээтэй холбоотой зардлыг нэмж төсөвлөсөн.

Дээж худалдан авах: Гаалийн болон хорио цээрийн лабораториудын үйл ажиллагаанд шаардлагтай стандартад дээж худалдан авах зардлыг тооцож төсөвлөсөн.

Засгийг газрын гадаад шилжүүлэг: Гаалийн байгууллага нь Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн орон тул жил бүр гишүүнчлэлийн татвар 27,000 евро төлдөг. Уг зардал валютын ханшны өсөлтөөс шалтгаалж өссөн болно.

| | | | | | | | | | |
|----|--|--------------|---------------|--------------|--------------|--------------|-------------|--------------|--------------|
| 40 | Дотоод албан томилолт | 298,647.3 | 641,228.8 | 314,172.0 | 15,360.0 | - | - | 20,950.2 | 32,461.4 |
| 41 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,770,606.0 | 9,797,561.6 | 463,502.8 | 623,744.2 | 359,786.4 | 19,960.0 | 284,746.9 | 238,706.2 |
| 42 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,800.0 | 335,758.8 | 12,600.0 | 81,414.4 | 20,000.0 | 3,000.0 | 9,165.6 | 55,730.0 |
| 43 | Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ | 3,970,983.5 | 3,907,902.3 | 200,800.0 | 5,504.4 | - | - | 37,245.0 | 6,076.0 |
| 44 | Шүүхийн шийдвэрийн дагуу олгох | 266,368.0 | - | - | - | - | - | - | - |
| 45 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 26,449.6 | 121,668.4 | - | - | - | - | 4,860.0 | - |
| 46 | Харуул, хамгаалалтын зардал | 654,286.0 | 689,328.0 | 144,000.0 | 37,950.0 | 216,000.0 | - | 173,250.0 | 43,200.0 |
| 47 | Холбооны суваг ашигласны төлбөр | 899,922.5 | 1,138,249.0 | - | 9,000.0 | - | - | 3,420.0 | - |
| 48 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 15,473.2 | 22,527.2 | - | 9,000.0 | 2,600.0 | 3,146.0 | - | - |
| 49 | Даатгалын үйлчилгээ | 161,436.4 | 1,043,635.1 | 41,946.9 | 361,792.7 | 104,949.9 | 4,816.6 | 6,011.1 | 16,008.0 |
| 50 | Тээврийн хэрэгслийн татвар | 9,731.6 | 12,880.7 | 2,850.0 | 991.2 | 1,287.9 | 498.6 | 471.6 | 502.5 |
| 51 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 3,651.6 | 3,620.4 | 820.0 | 90.0 | 392.6 | 188.8 | 286.0 | 363.0 |
| 52 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 221,150.3 | 1,503,542.2 | 33,100.0 | 10,736.0 | 6,321.0 | 3,630.0 | 7,200.0 | 8,730.0 |
| 53 | Газрын төлбөр | 21,083.0 | 25,549.5 | 7,248.9 | 775.9 | - | - | 103.6 | 2,196.7 |
| 54 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 491,270.3 | 992,900.2 | 20,137.0 | 106,489.6 | 8,235.0 | 4,680.0 | 42,734.0 | 105,900.0 |
| 55 | Бараа үйлчилгээний бусад зардал | 277,205.0 | 1,161,564.2 | - | 37,000.0 | 8,500.0 | 8,000.0 | 6,504.0 | 3,500.0 |
| 56 | Бараа үйлчилгээний бусад зардал | 62,014.8 | 606,936.8 | - | 36,300.0 | - | - | 900.0 | 3,500.0 |
| 57 | Биеийн тамирын уралдаан, тэмцээн | - | 25,500.0 | - | - | - | - | - | - |
| 58 | Дээж худалдан авах | 20,700.0 | 100,000.0 | - | - | - | - | - | - |
| 59 | Нүүлгэн шилжүүлэх зардал | 35,800.0 | 130,000.0 | - | - | - | - | - | - |
| 60 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 158,690.2 | 299,127.4 | - | 700.0 | 8,500.0 | 8,000.0 | 5,604.0 | - |
| 61 | УРСГАП ШИЛЖҮҮЛЭГ | 1,768,121.1 | 5,266,901.3 | - | - | - | - | - | - |
| 62 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 90,000.0 | 96,200.0 | - | - | - | - | - | - |
| 63 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 90,000.0 | 96,200.0 | - | - | - | - | - | - |
| 64 | Бусад урсгал шилжүүлэг | 1,678,121.1 | 5,170,701.3 | - | - | - | - | - | - |
| 65 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 1,331,084.2 | 4,015,951.3 | - | - | - | - | - | - |
| 66 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 347,036.9 | 1,154,750.0 | - | - | - | - | - | - |
| 67 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 83,234,357.9 | 134,511,038.6 | 13,893,569.2 | 11,000,449.5 | 11,824,120.1 | 3,336,120.8 | 10,833,102.2 | 17,062,972.8 |
| 68 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 82,007,210.7 | 131,283,891.4 | 13,883,569.2 | 10,938,449.5 | 11,824,120.1 | 3,336,120.8 | 10,813,102.2 | 17,012,972.8 |
| 69 | Улсын төсвөөс санхүүжих | 82,007,210.7 | 131,283,891.4 | 13,883,569.2 | 10,938,449.5 | 11,824,120.1 | 3,336,120.8 | 10,813,102.2 | 17,012,972.8 |
| 70 | ТӨСӨВТ БАЙГУУЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС САНХҮҮЖИХ | 1,227,147.2 | 3,227,147.2 | 10,000.0 | 62,000.0 | - | - | 20,000.0 | 50,000.0 |
| 71 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,227,147.2 | 3,227,147.2 | 10,000.0 | 62,000.0 | - | - | 20,000.0 | 50,000.0 |
| 72 | АЖИЛЛАГСАД БҮГД | 2326 | 2568 | - | - | - | - | - | - |
| 73 | Улирдах ажилтан | 68 | 68 | - | - | - | - | - | - |
| 74 | Гүйцэтгэх ажилтан | 1737 | 1979 | - | - | - | - | - | - |
| 75 | Үйлчлэх ажилтан | 521 | 521 | - | - | - | - | - | - |

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР

ГАЗЛИЙН БАЙГУУЛАГЫН 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВӨЛӨЛТ

| № | Аймаг, Нийслэл | Сум, Дүүрэг | Боомтын нэр | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хэмжих нэгж | Хүчин чадал | Төслийн төрөл | Төслийн ангилал | Хугацаа | | Төсөвт өртөг /өмнөх | | Төсөвт өртөгийн нийт өөрчлөлт | | Санхүүжилт /өмнөх | | Нийт авсан санхүүжилт /сая төг/ | Байгууллагын санал | |
|---|----------------|-------------|-------------------------------------|--|-------------|--------------------------|--|--------------------|---------|--------|---------------------|----------|-------------------------------|----------|---|---|---------------------------------|--------------------|--|
| | | | | | | | | | Эхлэх | Дуусах | 2022 | 2023 | 2022 | 2023 | Төсвийн төсөлд тусгах төсөвт өртөг /сая төгрөг/ | Төсвийн төсөлд тусгах санхүүжих дүн /сая төг/ | | | |
| 1 | Баян-Өлгий | Өлгий | Баян-Өлгий аймаг дахь газрийн газар | И.Барилга байгууламж ШИНЭ | м2 | 1065.6 | Конторын барилга | Барилга байгууламж | 2024 | 2024 | | | 4,319.80 | 3,503.00 | 3,503.00 | 4,319.80 | | | |
| 2 | Увс | Улаангом | Увс аймгад дахь газрийн газар | Шийтгэх Гаалийн хяналт бүрдүүлэлтийн барилга ШИГЖИХ | м2 | 12,24м зөөрхтэй 2 давхар | Конторын барилга | Барилга байгууламж | 2022 | 2024 | 670.00 | 1,198.40 | 2,685.20 | 670.00 | 1,198.40 | 1,868.40 | 816.80 | 816.80 | |
| 1 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Хөлийн боомтуудын албан хаагчдын орон сууцны их засвар /Улсын хэмжээнд/ ШИНЭ | айл | 297 | Орон сууц | Их засвар | 2024 | 2024 | | | | | | 3,602.00 | 3,602.00 | | |
| 2 | Улаанбаатар | Баянгол | Улаанбаатар хот дахь газрийн газар | Конторын барилгын их засвар | м2 | 1862 | Конторын барилга | Их засвар | 2024 | 2024 | | | | | | 2,372.00 | 2,372.00 | | |
| 3 | Дархан-Уул | Дархан | Дархан-Уул аймаг дахь газрийн газар | Конторын барилгын их засвар Ш.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ШИНЭ | м2 | 1072 | Конторын барилга | Их засвар | 2024 | 2024 | | | | | | 800.00 | 800.00 | | |
| 1 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Боомтын сэргалт-Гаалийн хяналтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ ШИНЭ | ш | 258 | Хяналтын тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж | 2024 | 2024 | | | | | | 46,778.50 | 46,778.50 | | |
| 2 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Гаалийн байгууллагын дата төвийн мэдээллийн ажиллагааг бийжүүлэх хамгаалалтын болон хөргөлтийн тоног төхөөрөмж | ш | 2 | Мэдээллийн төхөөрөмж, тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмж | 2024 | 2024 | | | | | | 35,742.00 | 35,742.00 | | |
| 3 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Компьютер техник хэрэгсэл | ш | 500 | Албан хэрэгсэл тусгай автомашин, автобус | Тоног төхөөрөмж | 2024 | 2024 | | | | | | 556.50 | 556.50 | | |
| 4 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Албан хаагчдыг зөвөөрлөх зориулалт бүхий техник хэрэгсэл | ш | 24 | Тулга чадвар сайтай автомашин, автобус | Тоног төхөөрөмж | 2024 | 2024 | | | | | | 2,750.00 | 2,750.00 | | |
| 5 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах зориулалт бүхий техник хэрэгсэл ШИНЭ | ш | 7 | Хүнд даацын тээврийн хэрэгсэл | Тоног төхөөрөмж | 2024 | 2024 | | | | | | 6,905.00 | 6,905.00 | | |
| 1 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Гаалийн албан хаагчдад зориулсан 60 айлын орон сууцны барилгын нэг маягийн зураг, төсөв ШИНЭ | ш | 1 | Орон сууц | ТЭЗҮ | 2024 | 2024 | | | | | | 825.00 | 825.00 | | |
| 2 | Төв | Сэргэлэн | ЧХОУНБГ | Гаалийн байгууллагын нэгдсэн архивын барилгын зураг төсөв | ш | 1 | Архивын барилга | ТЭЗҮ | 2024 | 2024 | | | | | | 460.00 | 460.00 | | |
| 3 | Улаанбаатар | Сүхбаатар | Гаалийн ерөнхий газар | Гаалийн бүрдүүлэлтийн нэгдсэн төвийг хиймэл оюун ухаанд суурилсан урсгал системээр хангах төлөвлөгөөний зөвлөмж үндэслэл боловсруулах НИЙТ ДҮН | ш | 1 | Мэдээллийн технологийн төлөвлөгөө | ТЭЗҮ | 2024 | 2024 | | | | | | 200.00 | 200.00 | | |
| | | | | | | | | | | | | | | | | 55,160.30 | 55,160.30 | | |